



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 132

Номгон

Үндэсний аюулгүй байдлын орон тооны  
бус салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, түүний шалтгаан нөхцлийг судлан тогтоох, арилгах арга хэмжээ авч ажиллах, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албатай харилцах асуудлыг хариуцсан Үндэсний аюулгүй байдлын орон тооны бус салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга-Аймгийн Засаг дарга

Зөвлөлийн нарийн бичгийн дарга-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүдэд-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга

Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга

Аймгийн Онцгой байдлын газрын дарга

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Аймгийн Засаг даргын дэргэдэх Гадаад харилцаа, аялал жуулчлалын албаны дарга

Тагнуулын ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь газрын дарга

Аймгийн Цагдаагийн газрын дарга

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Аймгийн Холбооны газрын дарга

2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ыг хэрэгжүүлэн ажиллахыг салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч/Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 45, 46 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР